



# МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН З А Х И Р А М Ж

2016 оны 5 дугаар  
сарын 19-ний өдөр

Дугаар 69

Улаанбаатар  
хот

## Ажлын хэсэг байгуулах тухай

1. Засгийн газрын 2016 оны 174 дүгээр тогтоолоор баталсан “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг”-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, боловсронгуй болгох талаар санал боловсруулах болон уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбогдуулан салбар хоорондын харилцан уялдааг хангуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

- |           |   |
|-----------|---|
| Ахлагч    | -Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга  |
| Дэд дарга | -Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч   |
| Гишүүд:   | -Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга;<br>-Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга;<br>-Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;<br>-Аж үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;<br>-Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга;<br>-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга;<br>-Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;<br>-Хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;<br>-Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга;<br>-Хүнс, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн дарга;<br>-Эрүүл мэнд, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга; |




- Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын дарга;
- Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын дарга;
- Онцгой байдлын ерөнхий газрын дарга;
- Цагдаагийн ерөнхий газрын дарга;
- Барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан Засгийн газрын референт.

Нарийн бичгийн дарга

- Нийслэлийн Засаг даргын хот байгуулалт, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан орлогч;
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Стратегийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга.

2. Ажлын хэсгийн ажиллах журмыг баталж мөрдүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогтод даалгасугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Ч.САЙХАНБИЛЭГ